

62



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 2/11

Бодь

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг
тодотгож хуваарилах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", Төсвийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 58 дугаар зүйлийн 58.4, 64 дүгээр зүйлийн 64.1.2, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх төсөл арга хэмжээнд хийгдсэн тодотголыг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлаар мэдээлж, тайланг хагас, бүтэн жилээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Р.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.АМАР-АМГАЛАН



1617087

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны
2/11 дүгээр тогтоолын хавсралт



2020 ОНЫ ОРОН НУТАГ ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨСӨВТ ХИЙСЭН ТОДОТГОЛ

Эх үүсвэр		
№	Төсөл хөтөлбөр арга хэмжээ	Төсөвт өртөг
1	2020 эхний үлдэгдэл	13,515.7
2	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт Сургууль	15,000.0
Нийт дүн		28,515.7

Тодотгол хийх хөрөнгө оруулалт

№	Төсөл хөтөлбөр арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Өвс	8,515.7
2	Ногоон өвс	10,000.0
3	Хивэг	10,000.0
Нийт		28,515.7